

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Орхон аймаг

2024-02-01

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Тайлант онд Төрийн мэдээлэл, төрийн цахим үйлчилгээний төв, иргэдтэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Төсөв санхүүгийн шинжилгээ, үнэлгээ, бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоо гарч Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу тус орон тоог нөхөн шаардлага, шалгуур хангасан албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан.	100
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтыг Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулан шаардлага хангасан иргэнийг томилж байна.	100
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/82 дугаар тушаалаар байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус зөвлөл нь албан хаагчийн ёс зүйн	100

		<p>тухай асуудал, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан тайлант оны 08 дугаар сард хуулийн танилцуулга, сургалтыг зохион байгуулсан.</p>	
2.4.	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	<p>Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй хүний нөөцийн стратегийн бодлогыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Тайлант онд Төрийн албаны зөвлөлөөс “Хүний нөөцийн аудит”-ын хяналт шалгалт хийгдэж зөрчилгүй дүгнэлт авсан.</p>	100
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<p>Төрийн албаны хүний нөөцийн бодлого, тогтвортой ажиллах нөхцөлийг ханган сул орон тоо гарсан үед хуулийн дагуу тухайн мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Тус мэдээлэл нь https://erdenet.mn/, https://csc.gov.mn/-д байршин иргэдэд ил тод мэдээлэгдэж байна.</p>	100
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	<p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн тайлант оны эхний хагас жилд Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэжлийн түвшинг үнэлсэн.</p> <p>Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоолын дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам өөрчлөгдөн, сүүлийн хагас жилийн ажлын гүйцэтгэлийг тус тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу үнэлгээ хийгдсэн. 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээ 65 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг “Үнэлгээний баг” хянан баталгаажуулж “Маш сайн” үнэлэгдсэн.</p>	100
Хэрэгжилтийн дундаж хувь:100			

-oOo-

*Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” 9 дүгээр хавсралт;

* Орхон аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 03-ны өдрийн Журам батлах тухай” А/750 дугаар захирамжийн 8 дугаар хавсралт